



ХҮДЭР СУМЫН АРДЧИЛСАН  
НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-07-30 № ЦА-2022/ОН-НА-34  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Хүдэр сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Хүдэр сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Хүдэр сумын Ардчилсан намын хорооны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хүдэр сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр  
1...4... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**




**НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО**

- 1.1. Эрүүл мэнд, биеийн тамир спорт**
- 1.1.1 Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.
  - 1.1.2 Сумын эрүүл мэндийн төвийг мэргэжлийн эмч сувилагчаар бүрэн хангаж ажиллах бодлого баримтлан ажиллана.
  - 1.1.3 Эрүүл мэндийн төвд ахмадын болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх кабинет ажиллуулна.
  - 1.1.4 Эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал хүртээмжийг сайжруулж эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэхэд ААН, байгууллага иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
  - 1.1.5 Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулах ажлыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
  - 1.1.6 Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.
  - 1.1.7 Нийтийн биеийн тамирыг орон нутагтаа хөгжүүлэх ажлын хүрээнд тус салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого барин ажиллана.
- 1.2. Боловсрол**
- 1.2.1. СӨБ-ын “Багш хөгжил” төвийн тоног төхөөрөмж техник хэрэгслийг шинэчилж багш нарын ажлын байран дээрээ хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
  - 1.2.2. Сурагчдын дотуур байрны их засварыг цогцоор нь шийдвэрлүүлэх, хүүхдийн амьдрах орчныг сайжруулах бодлого баримтлан ажиллана.
  - 1.2.3. Гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын материалаар хангуулах ажлыг зохион байгуулж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
  - 1.2.4. СӨБ-ын сургалтын чанарыг сайжруулж, СӨБ-ын насны хүүхдүүдийн сурах таатай орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
  - 1.2.5. Багш нарын нийгмийн асуудлыг анхаарч, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.



- 1.2.6. Сумын харьяат оюутан сурагчид болон багш нарыг гадаад дотоодын сургуульд суралцах, сургалтад хамруулж, сумандаа сайхан ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтлан ажиллана.
- 1.2.7. Сумын боловсон хүчний бодлогыг сайжруулж, хөрвөх чадвартай мэргэжлийн боловсон хүчний нөөцийг бүрдүүлэн ажиллана.



### **1.3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт**


- 1.3.1. Сумын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн судалгааг жил бүр шинэчлэн гаргаж ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.3.2. Ажил хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэлтэй иргэдийг бүхий л талаар дэмжин ажил олголтын эрэлт хэрэгцээ ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн иргэдэд мэргэжил эзэмшүүлэх давтан сургах ажлыг аймгийн ХХҮХ болон ААН байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 1.3.3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН байгууллагын ажлын байрны 50-иас доошгүй хувьд орон нутгийн иргэдийг ажиллуулах бодлого баримтлан ажиллана.
- 1.3.4. Залуу гэр бүлийг орон сууцаар хангах хөтөлбөр боловсруулан бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.3.5. Малчдын гар дээрх арьс шир түүхий эдийг боловсруулах жижиг оврын цех байгуулах иргэдийн санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.3.6. Мод бэлтгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүдийг түшиглэн хаягдал мод үртсийг ашиглан мод модон материалын үйлдвэр байгуулах санал санаачилгыг бодлогоор дэмжин ажиллана.
- 1.3.7. Сумын төвд стандартын ногоо хадгалах зоорьтой болох ажлыг холбогдох дээд шатны байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.3.8. Малгүй гэр бүлийг малжуулах хөтөлбөр боловсруулан зохион байгуулж ажиллана.
- 1.3.9. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

### **2.1. Хүнс хөдөө аж ахуй**

- 2.1.1. Тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулж малын тогтвортой өсөлтийг хангаж, мал аж ахуйн газар тариалангийн бүс болгох бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 2.1.2. Газар тариалан, төмс хүнсний ногоо, арьс ширний жижиг дунд ЖД үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.
- 2.1.3. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгжүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлого барьж ажиллана.

- 2.1.4. Өвс тэжээл бэлтгэх үйл ажиллагаа эрхэлдэг ААН, иргэдийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг улсын нөөцөд нийлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.1.5. Малчдын хоршоо, бүлэг байгуулах санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.6. Малчдын сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн боловсруулах цех ажиллуулах санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.7. Төв суурин газар зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн худалдаанд иргэд ААН-үүдийг оролцуулж бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.



## **2.2. Байгаль орчин**


- 2.2.1. Байгаль орчны экологийн тэнцвэртэй байдлыг хангаж, байгаль орчныг хамгаалах түүний баялгийг зөв зохистой ашиглахад төр, иргэн, ААН байгууллагын хоорондын харилцааг зохицуулах бодлого барьж ажиллана.
- 2.2.2. Байгаль орчны тухай багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.2.3. Ойжуулах төсөл боловсруулан орон нутагтаа хэрэгжүүлнэ.
- 2.2.4. “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.
- 2.2.5. Уул уурхайн нөхөн сэргээлтийг хийлгэх ажлыг бичил уурхайчид, нөхөрлөл, иргэдтэй хамтран зохион байгуулж, үйл ажиллагааны хэрэгжилтэд хийх хяналтын ажлыг эрчимжүүлнэ.
- 2.2.6. Сумын хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой газар нутгийн судалгаа гаргаж, тус үйл ажиллагааг эрхлэхээр санал санаачилга гаргасан иргэд, ААН-ыг бодлогоор дэмжиж ажиллана.

## **2.3. Дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ**

- 2.3.1. Сумын төвийн зам болон хорооллын замыг засварлаж тэмдэг тэмдэглэгээ суурилуулах ажлыг зохион байгуулна.
- 2.3.2. Сумын цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, айл өрхийг төвлөрсөн шугамд холбох ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.3.3. Дулаан хангамжийн эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангахын тулд уурын зуухны засвар үйлчилгээ бэлэн байдлыг хангуулан ажиллана.
- 2.3.4. Сумын спортын ордон барих ажлыг санаачилж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.3.5. Ерөнхий боловсролын сургуулийн багтаамж хүрэлцээ дутмаг байгаа тул сумын бага сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулах саналыг төсөвт тусгуулахаар холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлж ажиллана.



## ГУРАВ. НУТГИЙН ЗАХИРГАА, ТӨСӨВ САНХҮҮ



- 3.1. Төсөв санхүү, төрийн захиргаа**
- 3.1.1 Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, орлогын төрөл тус бүр дээр жигд ханган биелүүлэх ажлыг зохион байгуулж, төсвийн зарлагын гүйцэтгэлийг иргэдэд ил тод нээлттэй байлгана.
- 3.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.
- 3.1.3 Төрөөс иргэдэд хүртээх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, төрийн захиргааны албан хаагчдыг хүнд суртал, улс төржилтөөс ангид байлгах бодлого баримтлан ажиллана.
- 3.1.4 Сумын иргэдийн нийгмийн баталгааг сайжруулахын тулд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.1.5 Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор “Төрийн үйлчилгээний нэг цэг”-ийг ажиллуулна.

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

